

2026 ОНЫ 03 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2026-03-17

Өндөртолгой

Нийслэл, дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2026 оны 03 дугаар сарын 24-ний “Мягмар” гарагт 12.00 цагт Засаг даргын Тамгын газрын холбогдох бодлогын хэлтэст албан бичгээр, Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд 16.00 цагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн (ERP Н.Батцэнгэл)-д word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлэхдээ Нийслэлийн Хяналт-шинжилгээ үнэлгээний газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 оны 44 дүгээр зөвлөмжийн дагуу дараах шаардлагыг ханган тайлагнаж ажиллана уу.

1. Хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах, үйл ажиллагааны явц бус гарц, үр дүнг тайлагнах.

2. Үүргийн биелэлтийг тогтоосон хугацаанд, нотлох баримтын хамт, бүрэн гүйцэд тайлагнах.

3. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага бус үндсэн буюу бодлого хэрэгжүүлэгч байгууллага нэгтгэн тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1.	Сурагчдын хэлний мэдлэг, чадварыг сайжруулах зорилгоор Англи хэлний хичээлийг гадаад багшаар заалгах хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс
2.	Нийслэлийн хэмжээнд архидан согтуурах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах ажлыг зохион байгуулж, хяналт тавих.	Цагдаагийн хэлтэс
3.	Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн нэр төрийг гутаан доромжлох, залилах, хүчирхийлэлд уриалах, садар самуун явдлыг сурталчлах зэрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлүүдийг таслан зогсоох, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар судалгаа, санал боловсруулж, НИТХ-д танилцуулах.	Цагдаагийн хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс
4.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны “Төрийн зарим үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэн, хуулийн этгээдэд төрийн үйчилгээг цахим хэлбэрээр хүргэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах.	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Нийт байгууллагууд
5.	Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, санхүүгийн сахилга батыг сайжруулж ажиллах.	Санхүү төрийн сангийн хэлтэс, Нийт байгууллагууд
6.	Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэр дэх орон сууцны хорооллын дотор, гаднах зогсоолын менежментийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийх асуудлыг судлах.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
7.	Үерийн эрсдэлтэй бүсэд байгаа айл	Газар зохион байгуулалтын алба,

	өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах.	Онцгой байдлын хэлтэс
8.	Шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай захирамж гаргуулж, болзошгүй халдварт өвчнөөс сэргийлж ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулах.	Онцгой байдлын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн төв
9.	Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлж, нөхөн тарилтыг хийж, хог хаягдалгүй орчинг бий болгох.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Гэрэлтүүлэг Ногоон байгууламж ОНӨААТҮГ
10.	Орон сууцны барилгын гадна фасадны худалдан авах ажиллагааг эрчимжүүлэх.	Худалдан авах ажиллагааны алба
11.	Уурын зуух болон хийн түлшинд шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Илч-Орд ОНӨААТҮГ
12.	ТҮЦ-үүдийг нүүлгэх ажлыг зохион байгуулах.	Газар зохион байгуулалтын алба
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
13.	Ипотекийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх хүсэлтийг төлөвлөн хүргэх	Тамгын газрын дарга, Санхүү төрийн сангийн хэлтэс
14.	Төсвийн хөрөнгөөр завсарлагдсан орцуудын арчлалт хамгаалалтад анхаарах, СӨХ-д албан бичиг хүргэх	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
15.	Нийтийн эзэмшлийн болон орчны цэвэрлэгээ үйлчилгээ зохион байгуулах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Тохижилт ОНӨААТҮГ, Нийт байгууллагууд
16.	Байгууллагынхаа угтах хэсгийн орчны тохижилт, албан хаагчийн харилцаа, хандлага, хувцаслалт, үйл ажиллагаагаа сурталчлан ажиллахад анхаарах	Нийт байгууллагууд
17.	Зорилтот жилийн төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд анхаарах	Нийт байгууллагууд
18.	Багахангай марафон-2026 УАШТ зохион байгуулах ажлын хэсэг байгуулах, ажлын хэсгийн хурлыг зохион байгуулах	Нийгмийн хөгжлийн хэлтэс
19.	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх нөхөн тарилт хийх, нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Гэрэлтүүлэг Ногоон байгууламж ОНӨААТҮГ
20.	Дүүргийн ААНБ-ын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаатай танилцах хуваарь гаргах, зохион байгуулах	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
21.	Эрчим хүчний төслүүдийн талаарх уулзалт зохион байгуулах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
22.	“Жижиг дунд, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, ААНБ-ын үйл ажиллагааг эрчимжүүлэх, дэмжих” уулзалтын товыг гаргах, зохион байгуулах	Нийгмийн хөгжлийн хэлтэс
23.	Шилэн дансны зөрчлийг арилгах хугацаатай үүрэг өгөх, албан бичиг төлөвлөн хүргэх	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
24.	2025 оны хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзах, эвдрэл гэмтлийг засварлуулах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
25.	Төсвийн тодотголд бэлтгэх	Санхүү төрийн сангийн хэлтэс
26.	Аудитын шалгалт дуусаж байгаатай холбогдуулан зөрчилгүй дүгнүүлэх	Санхүү төрийн сангийн хэлтэс, Нийт байгууллагууд

27.	Жоншны шороо зөөвөрлөж байгаа авто машины хөдөлгөөнийг хязгаарлах, хяналт тавих	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Цагдаагийн хэлтэс
28.	Beatles хамтлагийн дууны тэмцээнд сурагчдыг бэлтгэн оролцуулах	Соёлын ордон, 91,94 дүгээр сургууль
29.	Зорилтот жилийн хүрээнд гадаадад туршлага судлах иргэд, албан хаагчдын бичиг баримтын бэлтгэх ажлыг зохион байгуулах	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТЦЭНГЭЛ